



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 23 өдөр

Дугаар A/472

Улаанбаатар хот

Г Т
Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого батлах тухай Засгийн газрын 24 дүгээр тогтоолын 2.4 дүгээр зүйлийн 2.4.1 дэх заалтын 2.4.1.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, Эрүүл ажлын байр шалгаруулах журмыг нэгдүгээр, комиссын бүрэлдэхүүнийг хоёрдугаар, комиссын ажиллах журмыг гуравдугаар, шалгуур үзүүлэлтийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, Эрүүл ажлын байрыг шалгаруулах орон нутгийн комиссыг мэргэжлийн удирдлагаар ханган, Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, Эрүүл ажлын байрыг шалгаруулах үйл ажиллагааг журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /Б.Цогтбаатар/-д даалгасугай.


3. Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, эрүүл ажлын байрыг улсын хэмжээнд шалгаруулахад шаардагдах төсөв, шагналын зардлыг Эрүүл мэндийг дэмжих сангийн төсөвт тусган, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн газар /Д.Ганцэцэг/-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2009 оны 184, 2013 оны 197 дугаар тушаалыг тус тус хүчингүйд тооцсугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ



081465

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 11 дугаар сарын 23 өдрийн
А/Ч дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Нэг. Нийтлэг зүйл

1.1 Хамт олны эрүүл мэндийг дэмжих санал, санаачлага, үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагыг шалгаруулах, шагнаж урамшуулах, сурталчлах, тогтвортой байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2 Улсын хэмжээнд дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэх шалгаруулалтын улсын комисс (ШУК)-ыг Эрүүл мэндийн яамны дэргэд, Аймаг, нийслэлийн хэмжээнд шалгаруулах дэд комиссыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дэргэд байгуулан ажиллуулна.

1.3 Эрүүл мэндийг дэмжих ажлуудыг санаачлан, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж, шалгарсан байгууллагад тухайн оны өргөмжлөлийг ШУК-ын шийдвэрээр, Аймаг, нийслэлд дэд комиссын шийдвэрээр тус тус олгоно.

1.4 Байгууллага, хамт олны эрүүл мэндийг дэмжсэн үйл ажиллагааг “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага” болон “Эрүүл ажлын байр” гэсэн хоёр ангиллаар шалгаруулна. Зөвхөн нэг ангилалд болон дээрх хоёр ангилалд оролцож болно.

1.5 Дээрх үйл ажиллагааг улсын хэмжээнд жил бүр тогтмол зохион байгуулж, явуулна.

Хоёр. Нэр томъёо

2.1 “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага” (ЭМДБ) гэдэгт хамт олон, олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх сургалт, сурталчилгааг тогтмол явуулдаг, уриалга, хөдөлгөөн өрнүүлдэг, нийгэмд үйлчлэх, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлсэн байгууллагыг хэлнэ.

2.2 “Эрүүл ажлын байр” (ЭАБ) гэдэгт ажлын байранд эрүүл, аюулгүй орчин бүрдүүлсэн, ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд тогтмол хамруулан, хяналт тавьж ажилладаг, эрүүл хоол хүнсээр үйлчилдэг, нийгмийн хариуцлагатай ажил олгогчийг хэлнэ.

2.3 “Дасгал, хөдөлгөөнийг хэвшүүлсэн хамт олон” гэж ажлын байранд дасгал, хөдөлгөөн тогтмол (6 сар ба түүнээс дээш хугацаагаар) хийж хэвшсэн, үр дүн нь гарсан байхыг хэлнэ.

2.4 “Эрүүл хооллолтыг хэвшүүлсэн хамт олон” гэж ажлын байранд эрүүл, зохистой хоолны сонголт бүхий цэсээр тогтмол үйлчилдэг, үр дүн нь гарсан байхыг хэлнэ.

2.5 “Эрүүл мэндийн үзлэгийг хэвшиүүлсэн хамт олон” гэж ажиллагсдыг жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт (7 ба түүнээс дээш төрөл) хамруулж хэвшсэн, тодорхой санхүүжилтийг энэ үйл ажиллагаанд зарцуулсан, үр дүн нь гарсан байхыг хэлнэ.

2.6 “Архи, тамхигүй хамт олон” гэж ажлын байранд архи, тамхинаас татгалзах хөдөлгөөн өрнүүлж, амжилтад хүрсэн, тодорхой санхүүжилтийг энэ үйл ажиллагаанд зарцуулдаг байхыг хэлнэ.

2.7 “Таргалалт, илүүдэл жингээ бууруулсан хамт олон” гэж хамт олон, байгууллагын хэмжээнд жингээ бууруулах аян тогтмол зохион байгуулж, илүүдэл жинтэй хүмүүсийн 2/3 нь биеийн жингийн индексийг хэвийн хэмжээнд хүргэсэн байхыг хэлнэ.

Гурав. Шалгаруулалт ба урамшуулалт

3.1. ЭМДБ ба ЭАБ шалгаруулах үйл ажиллагаа нь 2 үе шаттайгаар явагдах бөгөөд эхний шатыг аймаг нийслэлд, хоёр дахь шатыг улсын хэмжээнд дүгнэнэ.

3.2. Эхний шатны шалгаруулалт:

3.2.1 Эхний шатны шалгаруулалтыг дэд комисс зохион байгуулж, шалгаруулна.

3.2.2 ЭМДБ ба ЭАБ болох зорилт тавин ажиллаж байгаа байгууллага нь дэд комисст хүсэлтээ албан бичгээр холбогдох материалын хамт жил бүрийн 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлсэн байна.

3.2.3 Дэд комисс жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор дүгнэлт гаргаж, ЭМДБ ба ЭАБ-ыг шалгаруулна.

3.2.4 Нийслэл болон орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар гэрчилгээг дагалдах мөнгөн шагналын хэмжээг тогтоож, шийдвэрлэн шагналыг гардуулна.

3.2.5 Нийслэл болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулах эхний шатны ЭМДБ, ЭАБ-д олгох гэрчилгээ нь гурван зэрэглэлтэй байна:

3.2.5.1 нэгээс доошгүй жил үйл ажиллагаа явуулсан, шалгуурт 60-74 оноо авсан байгууллагад 3 дугаар зэргийн,

3.2.5.2 нэгээс доошгүй жил үйл ажиллагаа явуулсан, шалгуурт 75-89 оноо авсан байгууллагад 2 дугаар зэргийн,

3.2.5.3 нэгээс доошгүй жил үйл ажиллагаа явуулсан, шалгуурт 90-100 оноо авсан байгууллагад 1 дүгээр зэргийн гэрчилгээг олгоно.

3.3. Хоёр дахь шатны шалгаруулалт:

3.3.1 Хоёр дахь шатны шалгаруулалтыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв зохион байгуулж, ШУК шалгаруулна.

3.3.2 Нэгдүгээр зэргийн гэрчилгээ авснаас хойш нэгээс доошгүй жил ажиллаж амжилтаа бататгасан байгууллага шалгаруулалтын материалыг цаасаар болон цахим хэлбэрээр албан бичгийн хамт жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд хүргүүлнэ. Бүрдүүлэх материал:

– Нийслэл болон орон нутгийн ЭМДБ, ЭАБ шалгаруулах дэд комиссын шийдвэр, хурлын тэмдэглэлийн хамт,

– Нэгдүгээр зэргийн гэрчилгээний хуулбар,

– Шалгаруулалтын дагуу хийсэн ажлыг фото зургаар баримтжуулах.

3.3.3 Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв нь хоёр дахь шатны шалгаруулалтын шаардлага хангасан байгууллагын материалыг хүлээн авч, дүгнэлтээ жил бүрийн 2-р сарын 01-ний өдрийн дотор ЭМЯ-ны дэргэдэх ШУК-т хүргүүлнэ.

3.3.4 Шалгаруулалтын улсын комисс шийдвэрийг жил бүрийн 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж, тухайн оны Засгийн газрын өргөмжлөл, батlamж авах байгууллагыг тодруулна.

3.3.5 Эрүүл мэндийн сайдын тушаалаар хоёрдугаар шатны шалгаруулалтад тэнцсэн байгууллагад “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”, “Эрүүл ажлын байр” цол, өргөмжлөл, тус бүр 2 сая төгрөгийн үнэ бүхий зүйлийг 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор гардуулна.

3.3.6 Шагнал гардуулах үйл ажиллагааг Нийгмийн Эрүүл мэндийн үндэсний төв зохион байгуулж, цол, өргөмжлөл, бусад шаардагдах санхүүжилтийг төсөвлөн ШУК-р шийдвэрлүүлсэн байна.

3.3.7 Шалгаруулалтын улсын комисс улсын өргөмжлөл, батlamж авсан байгууллагуудаас онцгой үр дүнд хүрсэн байгууллагыг сонгон шалгаруулж, тухайн оны ЭМДБ, ЭАБ “Тэргүүний байгууллага” цол, батlamж олгуулахаар тодорхойлолтыг Эрүүл мэндийн сайдад жил бүрийн 4 дүгээр сарын дотор танилцуулж, тушаал батлуулна.

3.3.8 Улсын хэмжээнд ЭМДБ, ЭАБ-аар шалгарсан байгууллага, “Тэргүүний байгууллага” хамт олныг шагнах өргөмжлөл, урамшуулалтын санхүүжилтийн эх үүсвэрийг Засгийн газрын сангийн тухай хууль, Дүрэм, журам батлах тухай 2017 оны Засгийн газрын 82 дугаар тогтоолын дагуу шийдвэрлэнэ.

3.3.9 Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр онцгой хувь нэмэр оруулсан, олон улсын туршлагыг амжилттай нэвтрүүлж үлгэр дууриал үзүүлсэн, олон нийтийг хамарсан санаачилга өрнүүлж, амжилтад хүрсэн байгууллагыг журмын дүгнэх хугацаанаас хамааралгүйгээр шалгаруулж, өргөмжлөл олгохыг зөвшөөрнө.

3.3.10 Нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн үйл ажиллагаанд санхүүгийн хөрөнгө оруулалт хийж, тодорхой үр дүнд хүрсэн байгууллага, хамт олонд ШУК-ын шийдвэрээр өргөмжлөл олгож болно.

3.3.11 Улсын хэмжээний ЭМДБ ба ЭАБ-аар шалгарсан байгууллагуудын туршлагыг олон нийтэд сурталчлах үйл ажиллагааг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв зохион байгуулна.

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 11. дугаар сарын 23. өдрийн
A/472 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Нэг. Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, Эрүүл ажлын байрыг шалгаруулах улсын комиссын бүрэлдэхүүн

- Дарга: ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн газрын дарга
- Нарийн бичгийн дарга: НЭМҮТ-ийн Эрүүл мэндийг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх албаны дарга
- Гишүүд: ЭМЯ-ны ТЗУГ-ын Хуулийн хэлтсийн дарга
- ЭМЯ-ны НЭМГ-ын Эрүүл мэндийн боловсрол, эрүүл мэндийг дэмжих асуудал хариуцсан мэргэжилтэн
- ЭМЯ-ны НЭМГ-ын Эрүүл ахуй, хөдөлмөрийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- ЭМЯ-ны СБТГ-ын Төр, хувийн хэвшлийн түншлэл хариуцсан мэргэжилтэн
- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчдийн төлөө газрын Хамтын ажиллагаа, олон нийттэй харилцах газрын дарга /зөвшилцсөнөөр/
- МХЕГ-ын Хөдөлмөрийн эрүүл ахуй, хяналтын улсын ахлах байцаагч /зөвшилцсөнөөр/
- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал

Хоёр. Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, Эрүүл ажлын байрыг шалгаруулах дэд комиссын бүрэлдэхүүн

- Дарга: Аймаг, нийслэлийн Засаг даргын орлогч
- Нарийн бичгийн дарга: Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн
- Гишүүд: Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйлдвэр, үйлчилгээний хэлтсийн дарга

Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга

Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын
эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын
Нийгмийн эрүүл мэндийн төв/хэлтсийн дарга

Аймаг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын
Хөдөлмөрийн эрүүл ахуй, хяналтын улсын
байцаагч

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 11 дугаар сарын 23 өдрийн
А/Ч2 дугаар тушаалын 3 дугаар хавсралт



КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

1.1. Комиссын зорилго

ЭМДБ, ЭАБ болохоор хэрэгжүүлсэн үйл ажиллагааг орон нутагт болон улсын хэмжээнд бодитой үнэлгээ өгч шалгаруулах

1.2. Удирдлага, зохион байгуулалт

1.2.1 Комисс нь ЭМДБ, ЭАБ-ыг шалгаруулах ажлыг удирдан зохион байгуулахад эрүүл мэнд, хөдөлмөрийн үйл ажиллагаатай холбоотой гарсан хууль, тогтоомж, тушаал, шийдвэр болон бусад холбогдох хууль эрхийн актыг мөрдлөг болгоно.

1.2.2 Комиссын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллаж, орон нутаг болон холбогдох байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.

1.2.3 Комиссын хурлын бэлтгэл ажлыг болон шалгаруулалтад ирүүлсэн материалуудыг бүртгэх ажлыг комиссын нарийн бичгийн дарга зохион байгуулж ажиллана.

1.2.4. Шалгаруулалтад ирсэн материалыг үнэлгээний шалгуурын дагуу үнэлэхээс гадна, хяналт үнэлгээг тухайн байгууллага дээр хийж, дүнг хурлаар хэлэлцэж, олонхийн саналаар шийдвэрлэнэ.

1.2.5. Комисс нь хоёр дахь шатны шалгаруулалтад тэнцсэн байгууллагыг газар дээр нь очиж танилцсан баталгаажуулна.

1.2.6 Комиссын нарийн бичгийн дарга нь тухайн орон нутгийн болон улсын хэмжээнд шалгарсан ЭМДБ, ЭАБ талаар болон газар зүйн байршлын мэдээллийн сан үүсгэж жил бүр мэдээллийг оруулна.

1.2.7 Комиссын нарийн бичгийн дарга нь шалгаруулалтад шаардагдах төсөв, хяналт үнэлгээний зардал, шагналын зардлын төслийг боловсруулан, хэлэлцүүлж, төсөвт тусган шийдвэрлүүлнэ.

1.2.8 Комиссын нарийн бичгийн дарга нь хурлын тэмдэглэл хөтөлж, хурлын дарга, гишүүдээр гарын үсэг зуруулсан байна.

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 11 дугаар сарын 23 өдрийн
14/2 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт

А. “ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГА” ШАЛГАРУУЛАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	Шалгуур	Оноо (100)
I. Эрүүл мэндийг дэмжих бодлого		
1.1 Эрүүл мэндийг дэмжих бодлогын бичиг баримттай байх	<p>Эрүүл мэндийг дэмжих хүний нөөцийн бодлого эсвэл заалт бүхий бол 2 оноо</p> <p>Эрүүл мэндийг дэмжих хүний нөөцийн бодлого, заалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй бол 1 оноо</p> <p>Эрүүл мэндийг дэмжих хүний нөөцийн бодлого, заалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө хэрэгжксэн бол 1 оноо</p> <p>Бодлого, заалтад хоол зүйч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, чийрэгжүүлэлтийн арга зүйч/тус бүр 0,5 оноо/ ажиллуулахаар тусгасан бол 2 оноо</p> <p>Хоол зүйч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, чийрэгжүүлэлтийн арга зүйч /тус бүр 0,5 оноо/ ажиллуулдаг бол 2 оноо</p> <p>Ажлын байрны дарамт, шахалт, хүчирхийлэлтэй тэмцэх, жэндериийн бодлоготой¹ бол 1 оноо</p> <p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, түүний тесөв, зардлыг баталж, хэрэгжүүлдэг бол 3 оноо;</p> <p>Онцгой байдлын үед авран хамгаалах, анхны тусlamжийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний төлөвлөгөөтэй бол 2 оноо</p> <p>Дээрх төлөвлөгөөний дагуу ажиллагсдыг сургадаг бол 2 оноо</p> <p>Онцгой байдлын үед авран хамгаалах, анхны тусlamжийн бэлэн байдлыг хангах гарын авлагатай бол 1 оноо</p> <p>Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн хяналт, үнэлгээ хийдэг бол 2 оноо</p> <p>Дээрх үнэлгээнд эрүүл зан үйлийн үзүүлэлтийг оруулж тооцсон бол:</p> <ol style="list-style-type: none"> архи, тамхинаас бүрмөсөн татгалзаж чадсан хүмүүсийн тоо 10 хувиас багагүй хувиар нэмэгдсэн бол 0.5 оноо таргалалт, илүүдэл жинтэй нийт хүмүүсийн 2/3 нь биеийн жингийн индексээ хэвийн буюу 18.5-24.9-д хүргэсэн бол 0.5 оноо dasgal, хөдөлгөөн тогтмол хийдэг хүмүүсийн тоо 10 хувиас багагүй хувиар нэмэгдсэн бол 0.5 оноо Эрүүл хоол, хүns хэрэглэдэг хүмүүсийн тоо, 10 хувиас багагүй хувиар нэмэгдсэн бол 0.5 оноо 	8 1 3 5 4
1.2 Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа,	<p>Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөөтэй бол 3 оноо</p> <p>Байгууллагын төсөвт эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжүүлэх санхүүжилтийг тусгасан бол 4 оноо</p>	7

¹Жендерийн тухай хууль.

санхүүжилт ийн төлөвлөгөө тэй байх	Ажиллагсдаа нийгмийн даатгалд бүрэн хамруулсан бол 1 оноо Ажиллагсдаа эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулсан бол 1 оноо	2
	Нийт оноо	
II. Эрүүл мэндийг дэмжих орчин		
2.1 Эрүүл аюулгүй, орчинд ажиллах, сурах, алжаал тайлах, амрах нөхцөл бололцоогоор хангагдсан байх	<p>“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, Хөдөлмөрийн эрүүл ахуй, Ажлын байрны орчин эрүүл ахуйн шаардлага /MNS 4990 – 2015/”-ыг хангасан бол 1 оноо</p> <p>Хоол, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтын байртай, шаардлагатай тоног, төхөөрөмжөөр хангагдсан бол 2 оноо</p> <p>Мэргэжлийн тогооч, технологич ажилладаг бол 1 оноо</p> <p>Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг горимын дагуу хадгалж, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэдэг бол 1 оноо</p> <p>Стандартын шаардлага хангасан ундны усны хүрэлцээтэй эх үүсвэртэй бол 1 оноо</p> <p>Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилтан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдсан, үйлчилгээнд мөрдөх зохистой дадлыг мөрдөж хэвшсэн бол 2 оноо</p>	8
	<p>Нүхэн жорлон, угаадасны нүх техникийн шаардлага /MNS 5924:2015/-д нийцэх ариун цэврийн байгууламж, угаалтуур, био жорлонтой бол 1 оноо</p> <p>Байгууллагын суултуур нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээнд нийцдэг бол 1 оноо</p>	2
	<p>Ариутгал, халдвартгүйтгэл тогтмол хийлгэдэг бол 1 оноо</p> <p>Хортон шавьж, мэрэгч устгах мэргэжлийн байгууллагатай гэрээтэй ажилладаг бол 1 оноо</p> <p>Байгууллага дээр сүүлийн 1 жилийн хугацаанд халдварт өвчин голомтлон гараагүй бол 2 оноо</p>	4
	<p>Номын сангийн өрөөтэй, тогтмол ажиллуулдаг бол 1 оноо</p> <p>Дасгал хөдөлгөөнөөр хичээллэх боломжоор хангагдсан чийрэгжилтийн өрөөтэй бол 1 оноо</p> <p>Ажиллагсад эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан хоолны газар, хооллох зориулалтын өрөөтэй бол 2 оноо</p> <p>Алжаал тайлах, амралтын тохижуулсан өрөөтэй бол 2 оноо</p> <p>Ажлын байранд бухимдал тайлах, сэтгэл заслын зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлдэг бол 1 оноо</p> <p>Хөхүүл эхийн хүүхдээ хөхүүлэх булан эсвэл өрөөтэй (хаалт, хүүхэд хуурайлах хэсэг, сандал, г.м)² бол 1 оноо</p>	8
2.2 Байгууллагын гадаад орчныг тохижуулсан байх	<p>Байгууллагын гадаад орчин нь ногоон бүстэй/зүлэгжүүлсэн бол 1 оноо</p> <p>Байгууллагын гадаад орчинд сүүдрэвч, сандал ширээ, суудалтай бол 1 оноо</p> <p>Байгууллагын дотоод орчинд болон өрөө, тасалгааг цэцэгжүүлсэн бол 1 оноо</p>	3

²50 эмэгтэй ажилтан ажиллаж буй нэгж тутамд булан/ өрөө тохижуулсан байна. Харин зөвхөн эрэгтэй ажилтантай байгууллагад энэ үзүүлэлт хамаарахгүй

³Засгийн газрын 224-р тогтоол

	Машин тавих зориулалтын зогсоолтой бол 1 оноо Байгууллагын явган хүний зам, талбай бүтэн, гэрэлтүүлэгтэй бол 1 оноо	2
	Байгууллагын явган хүний зам нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээнд нийцдэг бол 1 оноо Байгууллагын шат нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээнд нийцдэг бол 1 оноо	2
	Байгууллагын хог хаягдлын цэг нь стандартын дагуу байрласан бол 1 оноо Байгууллагын цэвэрлэгээг стандартын дагуу хийдэг бол 1 оноо	2
	Нийт оноо	31
III. Эрүүл мэндийг дэмжихэд хамт олны оролцоо ба хувь хүний зан зүйлийн өөрчлөлт		
3.1 Эрүүл мэндийн зан зүйлийн эерэг өөрчлөлтийг дэмжих, урамшуулах, хамт олон болон олон нийтэд сурталчлах үйл ажиллагаа хэвшсэн байх	Байгууллагын хамт олны эрүүл мэндийн талаарх мэдлэг, хандлага, дадлын суурь судалгаатай бол 1 оноо Байгууллагын хамт олны эрүүл мэндийн талаарх мэдлэг, хандлага, дадлын судалгааг тогтмол хугацаанд зохион байгуулдаг бол 2 оноо Судалгааны үр дүнд суурилсан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлдэг бол 2 оноо Ажиллагсдаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах төлөвлөгөөтэй бол 1 оноо	6
	Архигүй хамт олон болох хөдөлгөөн өрнүүлдэг бол 2 оноо Тамхигүй хамт олон болох хөдөлгөөн өрнүүлдэг бол 2 оноо Ажлын байранд 100 хувь архигүй орчин бүрдүүлсэн бол 2 оноо Ажлын байранд 100 хувь тамхигүй орчин бүрдүүлсэн бол 2 оноо	8
	Эрүүл мэндийн чиглэлээрх тэмдэглэлт өдрүүдийг ³ зохион байгуулдаг, идэвхитэй оролцдог бол 2 оноо	2
	Ажиллагсад эрүүл хоол, хүнсний сонголт бүхий цэсээр үйлчлүүлдэг бол 2 оноо Ажиллагсад эрүүл хоол хүнсний сонголт бүхий цэсээр хөнгөлөлттэй үнээр үйлчлүүлдэг бол 2 оноо Ажиллагсад шаардлага хангасан ундны цэвэр усаар үнэтэлбөргүй хангагддаг бол 1 оноо	5
	Байгууллагын эрүүл мэндийг дэмжих шийдвэр гаргах үйл ажиллагаандaa хамт олны төлөөллийг оролцуулдаг бол 1 оноо	1
	Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг санаачлан зохион байгуулдаг бол 2 оноо Бусад байгууллагуудын эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд оролцдог бол 1 оноо	7
	Ажлын байранд эрүүл мэндийн сурталчилгааны самбар тогтмол ажиллуулдаг бол 1 оноо Эрүүл мэндийг дэмжих сургалт, сурталчилгааны булан, танхимтай, тогтмол ажиллуулдаг бол 3 оноо	
	Ажиллагсдаа эрүүл мэндийн эрсдэлт зан үйлийг өөрчлөх талаар тогтмол сургалтыг бие даан зохион байгуулдаг бол 1 оноо Ажиллагсдаа эрүүл мэндийн эрсдэлт зан үйлийг өөрчлөх талаар тогтмол сургалт мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулдаг бол 1 оноо	2

	Байгууллагаас зохион байгуулсан эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд хамт олны гэр бүлийхнийг оролцуулдаг бол 1 оноо Нийт оноо	1 32
IV. Эрүүл мэнд ба нийгмийн үйлчилгээ		
4.1 Ажиллагсад\ суралцагсад\ын эрүүл мэнд, бие бялдрын чийрэгжилтийн түвшинг жил бүр тогтоож, орон нутгийн эрүүл мэндийн байгууллага-тай хамтран урьдчилан сэргийлэх үзлэгийг хийж, эрүүлжүүлэх бодитой арга хэмжээ авч хэвшилсэн байх	Эрүүл мэндийг дэмжих ажилтан, эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй бол 1 оноо	
	Эрүүл мэндийг дэмжих ажилтан, эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтонд эрсдэлт зан үйлийг өөрчлөх үйл ажиллагааны заалтууд тусгагдсан бол 1 оноо	
	Байгууллагын хамт олонд эрүүл мэндийн үзлэгийг жил бүр нэгээс доошгүй удаа явуулдаг бол 1 оноо	
	Байгууллагын хамт олонд эрүүл мэндийн үзлэгийн үр дүнд эмчлэн, эрүүлжүүлэх ажил зохион байгуулдаг бол 1 оноо	7
	Байгууллагын хамт олны бие бялдарын түвшин тогтоодог бол 1 оноо	
	Байгууллагын хамт олны бие бялдарын түвшинг тогтоосны дагуу сайжруулах үйл ажиллагаа зохион байгуулдаг бол 1 оноо	
	Хөгжлийн бэрхшээлтэй/гэр бүлийн хэн нэг нь хөгжлийн бэрхшээлтэй/ болон нийгмийн халамж үйлчилгээ шаардлагатай хүмүүстээ халамж, үйлчилгээ үзүүлэх талаар тодорхой ажил зохиодог бол 1 оноо	
	Нийт оноо	7

Б. “ЭРҮҮЛ АЖЛЫН БАЙР” ШАЛГАРУУЛАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	Шалгуур	Оноо (100)
I. Эрүүл ажлын байрыг дэмжих бодлого		
1.1 Эрүүл ажлын байрыг дэмжих бодлогын бичиг баримттай байх	Эрүүл ажлын байрыг дэмжих хүний нөөцийн бодлого эсвэл заалт бүхий бол 1 оноо	
	Эрүүл ажлын байрыг дэмжих хүний нөөцийн бодлого, заалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй бол 1 оноо	
	Байгууллагад хоол зүйч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, чийрэгжүүлэлтийн арга зүйч/ тус бүр 0,5 оноо/ ажиллуулахаар тусгасан бол 2 оноо	6
	Хоол зүйч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, чийрэгжүүлэлтийн арга зүйч/ тус бүр 0,5 оноо/ ажиллуулдаг бол 2 оноо	
	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, түүний төсөв, зардлыг баталж, хэрэгжүүлдэг бол 3 оноо;	3
	Ажлын байрны дарамт, шахалт, хүчирхийлэлтэй тэмцэх, жендерийн бодлоготой ³ бол 1 оноо	1
	Онцгой байдлын үед авран хамгаалах, анхны тусlamжийн бэлэн	4

³Жендерийн тухай хуулийн заалтийг ойлгоно.

	<p>байдлыг хангах арга хэмжээний төлөвлөгөөтэй бол 1 оноо Дээрх төлөвлөгөөний дагуу ажиллагсдыг сургадаг бол 2 оноо Онцгой байдлын үед авран хамгаалах, анхны тусlamжийн бэлэн байдлыг хангах гарын авлагатай бол 1 оноо</p> <p>Эрүүл ажлын байрыг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн хяналт, үнэлгээ хийдэг бол 1 оноо Дээрх үнэлгээнд эрүүл зан үйлийн үзүүлэлтийг оруулж тооцсон бол:</p> <ol style="list-style-type: none"> архи, тамхинаас бүрмөсөн татгалзсан хүмүүсийн тоо 10 хувиас багагүй хувиар нэмэгдсэн бол 1 оноо таргалалт, илуудэл жинтэй нийт хүмүүсийн 2/3 нь биеийн жингийн индексээ хэвийн буюу 18.5-24.9-д хүргэсэн бол 1 оноо dasgal, хөдөлгөөн тогтмол хийдэг хүмүүсийн тоо 10 хувиас багагүй хувиар нэмэгдсэн бол 1 оноо Эрүүл хоол сонгодог хүмүүсийн тоо 10 хувиас багагүй хувиар нэмэгдсэн бол 1 оноо 	
1.2 Эрүүл ажлын байрны үйл ажиллагаа, санхүүжилтийн төлөвлөгөөтэй байх	<p>Эрүүл ажлын байрны үйл ажиллагааны төлөвлөгөөтэй бол 2 оноо Байгууллагын төсөвт эрүүл мэндийг дэмжих, эрүүл ажлын байрны үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжүүлэх санхүүжилтийг тусгасан бол 3 оноо</p> <p>Ажиллагсдаа нийгмийн даатгалд бүрэн хамруулсан бол 1 оноо Ажиллагсдаа эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулсан бол 1 оноо</p>	5 2
	Нийт оноо	26
II. Эрүүл ажлын байрыг дэмжих орчин		
2.1 Dasgal хөдөлгөөнийг хэвшүүлсэн байх	<p>Ажлын байранд бүх ажиллагсад дасгал, хөдөлгөөнийг 6 ба түүнээс дээш сарын хугацаагаар хийж хэвшүүлсэн бол 3 оноо Ажлын байранд дасгал, хөдөлгөөн хийж хэвшүүлсэн туршлагаа сурталчилсан бол 2 оноо</p> <p>Байгууллагад дасгалын тоног төхөөрөмж 3-5 ба түүнээс дээш төрөлтэй бол 1 оноо, Байгууллагад дасгалын тоног төхөөрөмж 6 ба түүнээс дээш төрөлтэй бол нэмэлт 1 оноо, Дасгалын өрөөнд халуун, хүйтэн шүршүүр, хувцас солих өрөөтэй бол 1 оноо Хөхүүл эхийн хүүхдээ хөхүүлэх булан эсвэл өрөөтэй (хаалт, хүүхэд хуурайлах хэсэг, сандал, г.м) бол 1 оноо Ажиллагсад амрах эсвэл алжаал тайлах өрөөтэй бол 1 оноо</p> <p>Байгууллагын хамт олны бие бялдарын чийрэгжилтийн түвшин тогтоодог бол 1 оноо Байгууллагын хамт олны бие бялдарын чийрэгжилтийн түвшинг дээшлүүлэх үйл ажиллагаа зохион байгуулдаг бол 2 оноо</p>	5 5 3
	<p>Байгууллагын хоолны газар ажиллагсдад 9 сараас дээш хугацаагаар эрүүл хоолны сонголт бүхий цэсээр үйлчилсэн бол 2 оноо Байгууллагын хоолны газарт эрүүл хоолны цэсийг ажиллагсдад зориулан зохиосон бол 2 оноо Байгууллагын хоолны газарт эрүүл хоолны цэс, хоолны чанар, давс, өөх тосны хэмжээнд мэргэжлийн байгууллагын зөвлөгөө,</p>	6
2.2 Эрүүл хооллолтыг хэвшүүлсэн байх		

	үнэлгээ, хийлгэдэг бол 2 оноо	
	Байгууллагын ажиллагсдад эрүүл хоолны сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулдаг бол 2 оноо Эрүүл хоолоор үйлчилж хэвшсэн туршлагаа үндэсний болон орон нутгийн түвшинд сурталчилсан бол 2 оноо	4
	Хоолны газарт гар угаах, хатаах төхөөрөмжтэй бол 2 оноо, шавьж устгал, ариутгал тогтмол хийлгэдэг бол 2 оноо, хий, шатах бодисын хадгалалт шаардлага хангасан бол 2 оноо Ажлын байрны үндны усны эх үүсвэр чанарын шаардлага хангасан, усны чанарыг шинжилгээгээр баталгаажуулдаг бол 2 оноо	8
2.3 Архи, тамхинаас татгалзсан ажлын байртай байх	Архи, тамхигүй ажлын байр болох зорилт тавьж бодлого, төлөвлөгөөндөө тусгасан бол 1 оноо “Тамхи татах цэгийг” хуульд ⁴ нийцсэн зайд байрлуулсан бол 1 оноо Бодлого, төлөвлөгөө, үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагын арга зүйн зөвлөгөө авч, үнэлгээ, хийлгэдэг бол 2 оноо	4
	Архи, тамхины хор уршгийг ойлгуулсан, архи, тамхинаас гарах зөвлөмжийг байгууллагын мэдээ, мэдээллийн самбар, цахим шуудан, хуудсаар тогтмол түгээдэг бол 3 оноо Архи, тамхины хортой хэрэглээг таниулсан сургалтыг зорилтот бүлгийн ажиллагсдад жилд 5-с доошгүй удаа зохион байгуулдаг бол 2 оноо Байгууллагын дарга, захирал, удирдлагын зөвлөл нь архи, тамхигүй ажлын байр болох үйл ажиллагаанд тогтмол дэмжлэг үзүүлдэг бол 1 оноо 100% Архи, тамхигүй ажлын байр болсон бол 5 оноо	11
	Нийт оноо	46
	III. Эрүүл мэнд ба нийгмийн үйлчилгээ	
3.1 Эрүүл мэндийн үзлэгийг хэвшүүлсэн байх	Бүх ажиллагсдыг жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, хэвшүүлсэн бол 3 оноо /7 ба түүнээс дээш төрөл/ Урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан туршлагаа үндэсний болон орон нутгийн түвшинд сурталчилсан бол 2 оноо Эрүүл мэндийн үзлэгийн төрлийн тоог нэмэгдүүлсэн бол 1 оноо /Нарийн мэргэжлийн үзлэг 3 ба түүнээс дээш/ Эрүүл мэндийн нарийн мэргэжлийн үзлэгийн үр дүнд ажиллагсдыг эмчлэн, эрүүлжүүлсэн бол 1 оноо	7
	Байгууллагын ажиллагсад болон үйлчлүүлэгчдээс ажлын байрны орчин, нөхцлийн талаарх сэтгэл ханамжийн судалгаа тогтмол авдаг бол 2 оноо Байгууллагын ажиллагсад болон үйлчлүүлэгчдээс ажлын байрны орчин, нөхцлийн талаарх авсан сэтгэл ханамжийн судалгааны үр	9

⁴ Тамхины хяналтын тухай хууль

	<p>дүнг үйл ажиллагаандаа ашигладаг бол 1 оноо</p> <p>Ажиллагсдын ажлын бүтээмжийг дээшлүүлэх, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлээр судалгаа хийдэг, үр дүнг хэрэгжүүлдэг бол 2 оноо</p> <p>Ажиллагсдын ажлын бүтээмжийг дээшлүүлэх, эрүүл орчин бүрдүүлэх чиглэлээр стресс менежментийн арга хэмжээ, төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг бол 2 оноо</p> <p>Ажиллагсдын ажлын бүтээмжийг дээшлүүлэх, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлээр аялал, аян, өдөрлөг, зохион байгуулдаг бол 2 оноо</p>	
	Нийт оноо	16
IV. Эрүүл мэндийн зан үйл		
4.1 Эрүүл мэндийн зан үйлийн зэрэг өөрчлөлтийг дэмжих, урамшуулах, хамт олон болон олон нийтэд сурталчлах үйл ажиллагаа хэвшсэн байх	<p>Байгууллагын хамт олны эрүүл мэндийн талаарх мэдлэг, хандлага, дадлын суурь судалгаатай бол 1 оноо</p> <p>Байгууллагын хамт олны эрүүл мэндийн талаарх мэдлэг, хандлага, дадлын судалгааг тогтмол хугацаанд зохион байгуулдаг бол 2 оноо</p> <p>Судалгааны үр дүнд суурилсан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлдэг бол 2 оноо</p> <p>Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг санаачлан зохион байгуулж, бусад байгууллагуудыг оролцуулдаг бол 2 оноо</p> <p>Бусад байгууллагуудын эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд оролцдог бол 1 оноо</p> <p>Ажлын байранд эрүүл мэндийн сурталчилгааны самбар тогтмол ажиллуулдаг бол 1 оноо</p> <p>Эрүүл мэндийг дэмжих сурталчилгааны булан, танхимтай, тогтмол ажиллуулдаг бол 3 оноо</p>	5
	Нийт оноо	12